



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 4 сарын 13 өдөр

Дугаар 701

Улаанбаатар хот

Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газарт
мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх
ажлын мөрөөр авах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд хийсэн мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх ажлын хүрээнд өгөх зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2.Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөсүгэй:

2.1.Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулж буй журам, зааврыг хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах;

2.2.Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны өөрчлөлтийг тусган дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн мөрдүүлэх;

2.3.“Хэнтий-Ус” ХХК, “Хэнтий орон сууц” үйлдвэрийн газрын дүрмийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.Хэнтий аймгийн Засаг дарга Д.Аюурбунь, Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Билгээ нарт дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Төрийн албаны зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын өгсөн зөвшөөрлийг үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр баталж заасан чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

3.2.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын бүртгэл, судалгаа, төлөвлөлтийн үндсэн баримт бичгийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д нийцүүлэн бүрдүүлж ажиллах;

3.3.Орсон нутгийн өмчийн газрын төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлал, зааврын дагуу баталж, үнэлж ажиллах;

3.4.Орон нутгийн өмчийн удирдлагад Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг мөрдөх;

3.5.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах;

3.6.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг хэрэгжүүлж байх;

3.7.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он)-ийн хүрээнд орон нутгийн өмчийн компани, үйлдвэрийн газрын засаглалыг хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох.

4.Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зөвлөмжийн тайланг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд) -т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
701 дугаар тогтоолын хавсралт



ХЭНТИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ТУСАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт өмчийн харилцааны чиглэлээр дараах зөвлөмжийг өгч байна:

Нэг. Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулж буй журам, зааврыг хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах;

Хоёр. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны өөрчлөлтийг тусган дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн мөрдүүлэх;

Гурав. Төрийн албаны зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлийг үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр баталж заасан чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

Дөрөв. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн хяналт шалгалт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

Тав. Орон нутгийн өмчийн удирдлагад Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг мөрдөх;

Зургаа. Орон нутгийн өмчийн газар нь албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах, хэрэгжилтэд хяналт тавих, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг зөв хуваарилах үүднээс өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг дээрх журамд нийцүүлэн баталж мөрдүүлж ажиллах;

Долоо. Төрийн албан хаагчийн хувийн болон түүний боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, ажлын үр дүн, шагнал урамшуулал, бүтээл туурвил, ажлын туршлагатай холбоотой мэдээллийг агуулсан төрийн албаны хүний нөөцийн удирдлагын бүртгэл, судалгаа, төлөвлөлтийн үндсэн баримт бичгийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-д нийцүүлэх;

Найм. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Ес. Улс төрөөс ангид байж орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын албан тушаалд ~~төрийн улс төрийн албан тушаалтан~~ болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох;

Арав. “Хэнтий -Ус” ХХК, “Хэнтий орон сууц” үйлдвэрийн газрын дүрмийг хууль, эрх зүйн актад нийцүүлж батлах арга хэмжээ авах;

---oOo---

